

# БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

**Эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст 5.6 орчим хувь байхаар төсөөлж байна.**<sup>1</sup> Оюутолгойн бүлэг ордын нийт нөөцийн 80 гаруй хувь нь газрын гүнд оршдог ба эрдсийн өндөр агуулгатай гүний уурхай ашиглалтад орсонтой холбоотойгоор баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэнэ. Мөн нүүрс, төмрийн хүдрийн олборлолт өсөж, уул уурхай болон тээврийн салбарын өсөлтөд эергээр нөлөөлнө. Харин малын хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын уналт нь эдийн засгийн нийт үйлдвэрлэлийн өсөлтийг хязгаарлахаар байна. Цаашид цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр өрхийн хэрэглээ өсөж, төсвийн тэлэлтийн нөлөөгөөр дотоод эдийн засгийн эрэлт өсөхөөр байна. Мөн 2024 оны эхний хагас жилд үйлчилгээний салбарын хөдөлмөр эрхлэлт сайжирсан, үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн тоо болон зээл олголт нэмэгдсэн нь оны хоёрдугаарт хагаст үйлчилгээний салбарын эрэлтэд эергээр нөлөөлөхөөр байна.

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны жилийн эцэст 28.5 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 4.9 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.** Оюутолгойн гүний уурхайн нөлөөгөөр 2024 онд зэсийн баяжмалын экспорт 1,560 мянган тоннд хүрч нэмэгдэхээр байна. Түүнчлэн, хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг өргөтгөх зэрэг арга хэмжээнүүдийн

үр дүнд нүүрсний экспорт 78 сая тоннд, төмрийн хүдрийн экспорт 8,400 мянган тоннд, газрын тосны экспорт 4,210 мянган баррельд тус тус хүрч, нийт экспортын дүн 16.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Эдийн засгийн өсөлт, бизнесийн зээл нэмэгдэж буй нөлөөгөөр уул уурхай, үйлдвэрлэлийн салбарын тоног төхөөрөмж, барилгын материалын импорт өсөхөөр байна. Мөн өрхийн орлого өсөж, хэрэглээний зээл олголт нэмэгдсэнээр хүнс, хэрэглээний бараа, шатахууны импорт өсөх төлөвтэй байна. Ингэснээр нийт импорт 2024 оны эцэст 11.8 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

**Инфляц 2024 оны эцэст төв банкны зорилтот түвшин болох  $6 \pm 2$  хувийн дээд интервал орчимд байхаар төсөөлж байна.** Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн нь махны нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцыг нэмэгдүүлж болзошгүй байгаа бол 2025 онд нэгдсэн төсвийн нийт/урсгал зарлага тэлж байгаа нь эрэлт талаас инфляцыг өдөөх эрсдэлтэй байна. Түүнчлэн Тяньжин боомт дээрх чингэлгийн бөөгнөрөл удаан үргэлжилж, тээврийн үнэ өсөх, геополитикийн тогтворгүй байдлын улмаас улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг импортын голлох бараа бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ нэмэгдэх зэрэг инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлүүд хэвээр байна.

<sup>1</sup> Эдийн засгийн өсөлтийн 2023 оны гүйцэтгэл 2024 оны 8 дугаар сард эцэслэгдэн зарлагдаж, 7.4 хувьд хүрсэнтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлтийн 2024 оны өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс бага зэрэг буурууллаа.